



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 8 сарын 29 өдөр

Дугаар 215

Улаанбаатар хот

Г Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа Г  
эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оруулахыг  
зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 407 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн журам”-ын 5.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


1. “Улаанбаатар хотын даатгал” ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 1,050,000,000.00 /нэг тэрбум тавин сая/ төгрөгөөр нэмэгдүүлж, хавсралтад заасны дагуу хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оруулахыг зөвшөөрсүгэй.

2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 15 хоногийн дотор ирүүлэхийг “Улаанбаатар хотын даатгал” ХХК /М.Энхболд/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА

С.ДАВААСҮРЭН



Санхүүгийн зохицуулах хорооны  
2018 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн  
275 дугаар тогтоолын хавсралт

“УЛААНБААТАР ХОТЫН ДААТГАЛ” ХХК-ИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН  
ХЭМЖЭЭ, ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН

(төгрөгөөр)

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Эхний үлдэгдэл			Өөрчлөлт			Эцсийн үлдэгдэл		
		Хувьцааны тоо ширхэг	Нийт үнэлгээ /нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 100,000 төгрөгөөр/	Дүрмийн санд эзлэх хувь	Хувьцааны тоо ширхэг	Нэмэгдсэн	Хорогдсон	Хувьцааны тоо ширхэг	Нийт үнэлгээ /нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 100,000 төгрөгөөр/	Дүрмийн санд эзлэх хувь
1	Ц. Чинбат /ХГ79100277/	25,550	2,555,000,000.00	73%	6,918	691,800,000.00	-	32,468	3,246,800,000.00	71.36%
2	М. Энхболд /ЧД79050770/	9,050	905,000,000.00	25.86%	3,582	358,200,000.00	-	12,632	1,263,200,000.00	27.76%
3	Нийслэлийн өмчийн харилцааны газар /2576589/	400	40,000,000.00	1.14%	-	-	-	400	40,000,000.00	0.88%
	<b>Нийт</b>	<b>35,000</b>	<b>3,500,000,000.00</b>	<b>100%</b>	<b>10,500</b>	<b>1,050,000,000.00</b>	<b>-</b>	<b>45,500</b>	<b>4,550,000,000.00</b>	<b>100%</b>